

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 26 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2026-02

Улаанбаатар хот

2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн
талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн зөрчилгүй гэж нягтлан баталгаажуулсан Банкны 2025 оны санхүүгийн тайлан (“2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан”)-г Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) хянан хэлэлцээд, тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-20 дугаар тогтоолоороо дүгнэн (“ТУЗ-ийн дүгнэлт”), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА